

# ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт  
Газрын тос



## АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

2022 оны 6-р сарын 20

Өнгөрөгч долоо хоногт алтны ханш нээлтийн цэгээсээ 1.67 хувиар уналаа. Харин шинэ долоо хоногийн арилжаа нээгдэхэд алтны ханш 0.22 хувиар унаж 1836 ам.доллар боллоо.

Өнгөрөгч сард хэрэглээний үнийн индекс 1981 оноос хойшхи хамгийн өндөр буюу 8.6 хувь гарснаар инфляцийн хэт халаалтыг намдаахын тулд холбооны нөөцийн сан бодлогын хүүг хүлээлтээс өндөр буюу 75 суурь нэгжээр нэмэгдүүлсэн.

Холбооны нөөцийн сан инфляцийг намжаахын тулд мөнгөний бодлогыг эрчимтэй чангатгаснаар эдийн засгийн идэвхжил буурч 5-р сард АНУ-ын үйлдвэрлэл гэнэтийн уналтад орлоо.

Гэсэн хэдий ч ам.долларын ханш дээд цэгтээ хэвээр байгаа нь алтны эрэлтийг тодорхой түвшинд хязгаарлалаа.

Дэлхийн хамгийн том алтаар баталгаажсан биржийн арилжааны сан болох SPDR Gold Trust-ийн мэдээлснээр, Пүрэв гарагт түүний эзэмшиж буй алт 1063.94 тонн байсан бол Баасан гарагт 1.1%-иар өсч 1075.54 тоннд хүрчээ.

Техник шинжилгээгээр алтны ханш унах чиглэлд байгаа ба хүрэх боломжтой цэг 1720 ам.доллар орчимд байрлаж байна.



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

2022 оны 6-р сарын 20

Брент маркийн нефтийн фьючерс 20 цент буюу 0.2%-иар өсч, баррель нь 113.32 ам.доллар болжээ. АНУ-ын баруун Техасын түүхий нефтийн үнэ баррель нь 109.55 ам.долларт хүрлээ.

Барууны хориг арга хэмжээний улмаас Оросын газрын тос ихэнх орнуудад хүрч чадахгүй хэвээр байна. АНУ тэргүүтэй орнууд нефтийн стратегийн нөөцийг чөлөөлж, ОПЕК+-аас олборлолтыг нэмэгдүүлснээр нөхцөл байдал харьцангуй зөөлөрч байгаа ч нийлүүлэлтийн хомсдолыг бүрэн шийдвэрлэх боломжгүй юм.

Одоогийн хурдаар явбал аравдугаар сар гэхэд АНУ-ын стратегийн нөөц сүүлийн 40 жилийн доод түвшинд хүрч, 358 сая баррельд хүрэх тооцоолол гарлаа. Гэсэн хэдий ч АНУ-ын газрын тос, байгалийн хийн олборлолт нэмэгдэж байна.

Газрын тос, хийн цооногуудын тоо 6-р сарын 17 хүртэл долоо хоногийн дотор 740-д хүрсэн нь 2020 оны 3-р сараас хойших хамгийн өндөр үзүүлэлт гэж эрчим хүчний "Baker Hughes Co" компани баасан гарагт тайландаа мэдэгдэв.

Өнгөрсөн долоо хоногт Ливийн газрын тосны гарц өдөрт 100,000-150,000 баррель байсан бол газрын тосны сайд Мохамед Оун даваа гарагт Ройтерс агентлагт хэлэхдээ тус улсын нийт олборлолт өдөрт 700,000 баррель хүрсэн хэмээжээ.

Нэгэн цагт томоохон экспортлогч байсан Хятадаас газрын тосны бүтээгдэхүүний экспорт буурч, дэлхийн нийлүүлэлтийг хязгаарласан хэвээр байна.

5-р сард шатахууны экспорт өнгөрсөн оны мөн үеэс 45.5%-иар, дизель түлшний экспорт 92.7%-иар буурч, дотоодын эрэлт хэрэгцээ зогсонги байдалд орсон хэдий ч компаниуд экспортын квотоо дутуу гүйцэтгэсэн байна.

Golomt Capital published on TradingView.com, Jun 20, 2022 11:26 UTC+8

Light Crude Oil Futures, 1Q, WHEAT Q108.75 H109.36 L107.24 C107.71 -0.28 (-0.26%)  
 HA (P, close, O, SMA, S) 116.71  
 HA (50, close, O, SMA, S) 109.21



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.